



 Save the Children

30 YEARS
IN MONGOLIA

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН
SAVE THE CHILDREN IN MONGOLIA
1994-2024



МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН
SAVE THE CHILDREN IN MONGOLIA
1994-2024

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

ХАРИУЦЛАГА

- Бид хүүхдүүд, дэмжигч, хамтрагчдынхаа өмнө ил тод, хариуцлагатай байж, нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан, хэмжигдэхүйц үр дүнд хүрэх үүргийг хүлээнэ.

ТЭМҮҮЛЭЛ

- Бид өөрсдөдөө болон хамтрагчдадаа чанд шаардлага тавьж, алсын хараатай зорилго дэвшүүлэн, хүүхдийн төлөөх үйл ажиллагааныхаа чанарыг ямагт сайжруулахад тэмүүлнэ.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Бид хамтрагчдаа хүндэлж, ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрч, хамтдаа өсөн дэвжиж, хүүхдийн амьдралд эерэг өөрчлөлт бий болгохын төлөө ажиллана.

БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ

- Бид шинэ санаа, санаачилгад нээлттэй, өөрчлөлтөд бэлэн, эрсдэлд ухаалаг, зоримог байж, хүүхдийн төлөөх тогтвортой шийдлийг хүүхдүүдтэй хамт эрэлхийлнэ.

ШУДАРГА БАЙДАЛ

- Бид үнэнч шударга байдал, ёс зүйн өндөр хэм хэмжээг сахина. Бид үргэлж нэр төрөө эрхэмлэн ямагт хүүхдийн язгуур эрх ашгийг дээдлэн ажиллана.

OUR VALUES

ACCOUNTABILITY

- We take personal responsibility for using our resources efficiently, achieving measurable results, and being accountable to supporters, partners and, most of all, children. AMBITION We are demanding of ourselves and our colleagues, set high goals, and are committed to improving the quality of everything we do for children.

COLLABORATION

- We respect and value each other, thrive on our diversity, and work with partners to leverage our global strength in making a difference for children.

CREATIVITY

- We are open to new ideas, embrace change, and take disciplined risks to develop sustainable solutions for and with children.

INTEGRITY

- We aspire to live to the highest standards of personal honesty and behaviour; we never compromise our reputation and always act in the best interests of children.

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН АЛСЫН ХАРАА:

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг дэлхий ертөнцийг цогцлоохыг бид эрмэлзэнэ.

SAVE THE CHILDREN'S VISION:

Our vision is a world in which every child attains the right to survival, protection, development and participation.

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО:

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг дэлхий ертөнцийг цогцлоохыг бид эрмэлзэнэ.

Хүүхэд чиглэсэн дэлхий нийтийн хандлагад эргэлт хийж, хүүхдийн амьдралд урт хугацааны тогтвортой өөрчлөлт авчрахын төлөө бид хүчин зүтгэнэ. Хүүхдийг Ивээх Сан Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн эрхэд суурилсан хандлагыг таниулахаас ажлаа эхэлж, ажилгүйдэл, ядуурлын улмаас гудамжинд гараад байсан Монголын эмзэг бүлгийн болон хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд нэн түрүүнд тусламжийн гараа сунгасан юм. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлт бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдэл олохыг эрхэмлэн ажилладаг.

2030 он хүртэл хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох бодит дэвшил дараах гурван зорилтын хүрээнд хийгдэнэ:

1. ЭСЭН МЭНД АМЬДРАХ

Тав хүртэлх насны хүүхдийн урьдчилан сэргийлж болохуйц эндэгдлийг таслан зогсооно.

2. СУРАХ

Бүх хүүхэд чанартай суурь боловсрол эзэмшиж чаддаг болсон байна.

3. ХАМГААЛУУЛАХ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчдэг болсон байна.

SAVE THE CHILDREN'S MISSION:

Our mission is to inspire breakthroughs in the way the world treats children and to achieve immediate and lasting change in their lives.

GLOBAL BREAKTHROUGHS

We are working towards three global breakthroughs that will achieve real progress in bringing long-term, sustainable changes to the lives of children by 2030:

1. SURVIVE

No child dies from preventable causes before their fifth birthday.

2. LEARN

All children learn from a quality basic education.

3. BE PROTECTED

Violence against children is no longer tolerated.

ЗУРАГТ ТҮҮХЭНД ТАВТАЙ МОРИЛНО УУ

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан 30 жилийнхээ түүхэн ойд зориулан анх удаа гурван аравны түүхээ эмхэтгэн, зурагт ном хэвлүүлж байна. Энэхүү номд Хүүхдийг Ивээх Сангаас хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, боловсрол, хүүхдийн ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, хүмүүнлэгийн яаралтай тусламж зэрэг тэргүүлэх чиглэлүүдийнхээ хүрээнд санаачилж хэрэгжүүлсэн, бүтээн байгуулсан, түгээн дэлгэрүүлсэн томоохон ажлуудаасаа тоймлон гэрэл зургийн хамт багтаасан юм. Хүүхдийг Ивээх Сангийн олсон амжилт, хуримтлуулсан туршлага нь гадаад, дотоодын санхүүжүүлэгч байгууллага, хамтрагч талууд, үе үеийн ажилтнууд, чадварлаг баг, хамт олны хичээл зүтгэл, дэмжлэгтэй нягт холбоотой билээ. Монголын ирээдүй болсон хүүхэд, залуусын төлөө үнэтэй хувь нэмрээ оруулж, бидэнтэй хамтран ажиллаж, дэмжиж ирсэн Та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

Хүүхдийг Ивээх Сангийн зурагт түүхэнд тавтай морилно уу.

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн Суурин төлөөлөгч Лувсандоржийн Баян-Алтай

2024 оны 11 дүгээр сарын 01

WELCOME TO THE ILLUSTRATED HISTORY

In celebration of the 30th anniversary of Save the Children in Mongolia, we are proud to present this illustrated book, the first of its kind, compiling three decades of stories about our impact on the well-being of Mongolian children. This book highlights the range of projects initiated, implemented, and shared in the key focus areas of child protection, child rights governance, education, poverty reduction, health, and emergency humanitarian aid, all accompanied by powerful photographs.

The success of Save the Children is deeply intertwined with the efforts and support of both international and domestic funding organizations, our dedicated partners, multi-generations of employees, and our talented teams, as well as the unwavering support of the community.

We extend our heartfelt gratitude to everyone who has contributed to a brighter future for Mongolia's children and youth, and to all those who have collaborated with us along the way.

Welcome to Save the Children's illustrated storybook!

Bayan-Altai Luvsandorj, Country Manager and Representative,
Save the Children in Mongolia

November 1, 2024



Хүүхэд, залуусын орон Монгол

Аливаа улсын хөгжил цэцэглэлтийн үндэс нь олон төрлийн хүчирхийллээс ямагт хамгаалагдсан, бие, сэтгэцийн хувьд эрүүл, боловсролтой иргэд байдаг. Нийгэм хэр энэрэнгүй, хүнлэг байгааг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай иргэдээ төр хэрхэн халамжилж байгаагаар харж болдог. Төр хүүхдийн дээд эрх ашгийг цаг ямагт эрхэмлэж, хүний эрхийн суурь зарчмыг баримтлан, бодитой ажиллаж байгаа эсэхээр таньж тодорхойлж болно.


Хүн амын 3 хүн тутмын нэг нь хүүхэд учир, бусад улс оронтой харьцуулахад манай улс хүүхэд, залуусын орон юм. Хүн амын "Цонх үе"-ийг ашиглан, нийгэм рүү чиглэсэн бодлогыг системтэй явуулах үүрэг хүлээсэн Монгол Улсын Засгийн газрыг дэмжин ажилласан 30 жилийн түүхээ бид тоймлон өгүүлж байна.

Mongolia: The Land of Children and Youth

The foundation of any country's prosperity lies with its citizens, their physical and mental health, their education and their protection from all forms of violence. A society's compassion and humanity are reflected in how it cares for its children, its persons with disabilities, and its elderly citizens. As well, the strength of a nation can be measured by its commitment to respecting the best interests of children, upholding fundamental human rights, and implementing realistic policies.

With one in every three individuals being under 18 years, Mongolia stands out as a nation of children and youth. In this book, we summarize our 30-year history of supporting the commitment of the Government of Mongolia to systematically implement policies that benefit society during this critical "demographic window" of population growth.





Шилжилтийн давалгаанд ширвэгдсэн Монголын хүүхдүүд

Монгол Улс 1990-өөд онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжив. Монгол Улсын Засгийн газар энэхүү шилжилттэй зэрэгцээд 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангаж ажиллахаа илэрхийлсэн байдаг.

Шинэ Үндсэн хуулиа 1992 онд баталж, хүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах хөгжлийн замыг сонгож байгаагаа зарласан нь хүүхдийн төлөөх олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлсэн юм. Шилжилтийн эхний жилүүдэд хүн амын амьдрал доройтож, ажилгүйдэл, ядуурал эрс нэмэгдэж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ цөөрч, чанар нь муудсан байлаа.

Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Статистикийн үндэсний газраас хийсэн 1995 оны "Амьжиргааны түвшин тогтоох судалгаа"-гаар ажилгүйдэл, ядуурал нийгмийн нэг хурц, тулгамдсан асуудал болж, 1995 он гэхэд хүн амын 36,3% нь ядуурсан байв. Томоохон хотууд болон алслагдсан хөдөө орон нутагт сургууль завсардах, сургуулиас гарах явдал түгээмэл болжээ.

Сургуулийн дотуур байрны хоолны зардлыг төрөөс санхүүжүүлэхээ зогсоосон тул 1989-1992 онд дотуур байранд амьдардаг хүүхдийн тоо 2 дахин цөөрсөн байна. ЮНЕСКО-гийн 2000 оны "Бүх нийтийн боловсрол" үнэлгээгээр 1990-1995 онд цэцэрлэгийн тоо 909 байснаа 660 болж багассанаас гадна сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 27.9 хувиас 18.8 хувь болж буурав.

Олон айл өрх орлогогүй болж, архидалт, гэр бүлийн салалт ихсэж, өнчин, гэр бүлээсээ дайжин гудамжинд гарсан хүүхдийн тоо огцом нэмэгдсэн байна. "Хараа хяналтгүй" хүүхдүүдийн тоо 1990-өөд оны дунд үед 1.500-4.000 орчим болжээ. Энэ үед Хүүхдийг Ивээх Сан Монголын хүүхдүүдэд туслах, хүүхэд хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал руу чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болжээ.

Challenges Faced by Mongolian Children During the Transition

In the 1990s, Mongolia underwent a significant transition from a centrally administrated economy to a market economy. During this period, in 1990, the Government of Mongolia affirmed its commitment to fulfilling the rights of Mongolian children by joining the United Nations Convention on the Rights of the Child.

With the adoption of a new Constitution in 1992, Mongolia chose a path of development aimed at building a humane, civil, and democratic society, one which facilitated international cooperation for children. However, in the early years of this transition to a new political and economic system, the lives of all Mongolians deteriorated significantly. Unemployment and poverty surged, while the quality of education, health, and social services declined.

According to the 1995 "Living Standards Assessment" conducted by the National Statistics Office of Mongolia with support from the World Bank, unemployment and poverty emerged as acute societal issues, with 36.3% of the population classified as poor in that year. School dropouts became increasingly common in both large cities and remote rural areas.

Between 1989 and 1992, the number of children living in dormitories halved as the state ceased funding meals for dormitory students. UNESCO's 2000 "Education for All" assessment revealed a decline in the number of kindergartens from 909 to 660 between 1990 and 1995, while preschool enrollment fell from 27.9% to 18.8%.

Many families lost their sources of income, leading to a rise in alcoholism and divorce. Consequently, the number of orphans and children living on the streets sharply increased. By the mid-1990s, the estimated number of "unsupervised" children reached approximately 1,500 to 4,000. This dire situation underscored the urgent need for Save the Children to step in and implement projects and programs focused on child protection, education, health, and social security.



1994-2004

Үүдээ нээж, үйл ажиллагаагаа эхлэв

Монгол Улсын эдийн засаг, хүн амын амьдралын чанар нийгмийн шилжилтийн үед дордож, хүний эрхийн нөхцөл байдал хүнд болсон үед буюу 1994 оны 2 дугаар сард Хүүхдийг Ивээх Сан Монгол Улсад байгуулагдаж, Их Британийн Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага дор ажиллаж эхэлжээ. Ингэхдээ хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгохын ач холбогдлыг сурталчилах, хүүхдийн эрхэд суурилсан хандлагыг таниулахаас ажлаа эхэлсэн байна. Тухайн үеийн хүүхдийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, хүүхэд хамгааллын ажилтнуудын хүүхдийн эрхийн талаарх ойлголт, хүүхэд хамгааллын мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж байв. Хүүхдийг Ивээх Сан энэ үед захирал, орчуулагч, туслах ажилтан, жолооч гэсэн дөрвөн орон тоотой байжээ.

Save the Children Opens Its Doors

Save the Children was established in Mongolia in February 1994 and began working under the management of Save the Children UK. It was a time when the economy and quality of life were declining amid social transition, and human rights conditions were deteriorating. Our work began by advocating for the creation of a child protection system and promoting a child rights-based approach. We focused on strengthening the human resources of children's organizations and enhancing the knowledge and understanding of child protection among workers in the field. At that time, Save the Children had a small team of four: Director, Translator, Assistant, and Driver.



Зургийн тайлбар: Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн анхны хамт олон Хүүхдийг Ивээх Сан байгуулагдсаны 75 жилийн ой тэмдэглэж байгаа нь. 1994 он

Photo caption: Newly established team in Mongolia is celebrating the 75th anniversary of Save the Children. 1994



Жон Буклер

Жон Буклер 1994-1999 онд Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь анхны захирлаар ажиллажээ. Тэрээр, хүүхдийн байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллах эхлэлийг тавьж, Хүүхдийн эрхийн тухай конвенцийг таниулах, хүүхэд, эцэг эх, олон нийттэй ажиллах арга барилыг сайжруулахад анхаарч ажиллажээ. Мөн үндэсний болон томоохон хөгжлийн хөтөлбөрүүдэд хүүхдийн асуудлуудыг тусгуулахын зэрэгцээ орлого багатай, хөгжлийн бэрхшээлтэй болон малчдын хүүхдүүдийн боловсролд чиглэсэн төслүүдэд санхүүжилт татан хэрэгжүүлсэн байна.

John Beauclerk

John Beauclerk served as the first director of Save the Children in Mongolia from 1994 to 1999. He established a strong foundation for effective collaboration with children's organizations, focusing on raising awareness of the Convention on the Rights of the Child and improving methodologies for working with children, parents, and the community. In addition to integrating children's issues into major national development programs, he successfully raised funds for projects aimed at enhancing the education of children from low-income households, children with disabilities, and children from herder families.



Хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд рүү үйл ажиллагаагаа чиглүүлэв

Хүүхдийг Ивээх Сан 1996 онд Улаанбаатар хотод халамжийн 10, хөдөө орон нутагт 4 төв байгуулав. Халамжийн эдгээр төвүүд нь хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн хөгжлийн наад захын хэрэгцээг хангаж, хамгаалал, боловсрол, хөгжлийн үйлчилгээг үзүүлэх болжээ. Энэ туршлага хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдтэй ажилладаг төрийн болон бусад байгууллагын үйл ажиллагааны жишиг загвар боллоо. Энэхүү төслийн санхүүжүүлэгч нь Английн Хүүхдийг Ивээх Сан, Гөү Хэлп байгууллага байв.

Directing Our Activities to Children Without Supervision

In 1996, Save the Children established 10 welfare centres for children in Ulaanbaatar and 4 in rural areas. These centres provided protection, education, and developmental services to address the basic needs of children living without supervision and those engaged in work. This model has since become standard for the government and other organizations working with unsupervised and employed children. The project was supported by Save the Children UK and Go Help.



Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэв

Хүүхдийг Ивээх Сангаас олон нийтийн идэвхтэй хэсэг, нийгмийн ажилтнууд, эцэг эх, хүүхдүүдтэй ажилласан урт хугацааны, тогтвортой түншлэлийн үр дүнд 2001 оноос хүүхдийн төлөө ажилладаг төрөл бүрийн холбоо, төрийн бус байгууллагууд байгуулагдаж эхэлжээ. Хүүхдийн эрхийг дэмжигч иргэний нийгмийн хамгийн идэвхтэй байгууллагуудын төлөөлөл бол 2001 онд байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, Сургуулийн нийгмийн ажилтны холбоо юм.

Strengthening the Capacity of Civil Society Organizations

Since 2001, as a result of long-term and sustainable partnerships between Save the Children and active community members, social workers, parents, and children, a number of associations and non-governmental organizations dedicated to children were established. Among the most active civil society organizations supporting children's rights are the Association of Parents of Disabled Children and the Association of School Social Workers, both founded in 2001.



Сургуулийн өмнөх боловсрол олгох явуулын гэр цэцэрлэг

Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (1996-2000)-ийг боловсруулж, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцов. Шилжилтийн үед орхигдоод байсан, шийдэх зайлшгүй шаардлагатай асуудлын нэг болох хүүхдийн боловсрол, тэр дундаа сургуулийн өмнөх боловсролын талаар уг хөтөлбөрт тусгах ажлыг зохион байгуулав. Хүүхдийг Ивээх Сангийн санаачилсан явуулын гэр цэцэрлэгийн загвар нь боловсролын тогтолцооны салшгүй хэсэг, үндэсний хөтөлбөр болж, хөдөөгийн малчдын хүүхдийн гуравны нэгээс илүүд сургуулийн өмнөх боловсрол олгох “хувилбарт сургалт”-ын үйлчилгээг бий болгосон билээ. Тус төслийг Английн Хүүхдийг Ивээх Сан санхүүжүүлсэн байна.

Mobile “Ger-Kindergarten” for Pre-School Education

Save the Children actively participated in the development and implementation of the National Poverty Reduction Program (1996-2000). Our efforts ensured that children's education was included in this program, particularly pre-school education which had been overlooked during the transition period. The mobile “ger-kindergarten” model initiated by Save the Children has become an integral part of the national education system that provides an alternative program of pre-school education to more than a third of the children of rural herders. This project was funded by Save the Children UK.

Нийгмийн ажилтан бэлтгэхэд арга зүйгээр туслав

Хүүхдийг Ивээх Сангаас тухайн үеийн Улсын багшийн их сургуульд (өнөөгийн МУБИС) 1997 онд анх мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэх тэнхим байгуулагдахад удирдлага, арга зүйгээр хангаж, гарын авлага, сургалтын материал, санхүүгийн дэмжлэг үзүүлэв. Тус сургуулийг төгссөн нийгмийн ажилтнууд өнөөдөр төрийн болон төрийн бус байгууллага, боловсрол, хувийн хэвшлийн салбарт амжилттай ажиллаж, нийгмийн ажилтнуудыг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсаар байна. Хүүхдийг Ивээх Сан нийгмийн ажилтнуудад ажлын байрны зөвлөгөөг өгөх ажлыг хөгжүүлсээр, 2024 онд "Нийгмийн ажлын супервижн"-ы анхны гарын авлагыг боловсруулсан юм. Тус төслийг Английн Хүүхдийг Ивээх Сан санхүүжүүлсэн байна.

Providing Methodology for Training Social Workers

In 1997, Save the Children offered managerial and methodological assistance, and distributed manuals, training materials, and financial support to the department for training professional social workers established at the former State Pedagogical University (now the Mongolian National University of Education). Graduates from this program are now making valuable contributions to the discipline itself, as well as successfully working in government and non-governmental organizations, and in the education and private sectors. Save the Children continues to conduct on-the-job counselling for social workers and, in 2024, developed the first manual for "Social Work Supervision." This project was funded by Save the Children UK.



Хамгаалал шаардлагатай, хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүдийг анхаарав

Хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааг олон нийтэд түшиглэсэн хандлага, арга зүйгээр явуулах нь илүү ач холбогдолтой болохыг 2000 оноос эхлэн таниулж, үйл ажиллагаагаараа баталсан юм. Олон нийтэд түшиглэсэн "Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв"-үүдийг байгуулж, амьдрах таатай орчин, эцэг эхийн хайр халамж, хамгаалал дутсан хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг өргөжүүлж, ганцаарчилсан зөвлөгөө өгөх, кейс менежмент, гэр бүлд нь эргэн нэгтгэх, зөвлөн туслах, гэр бүлд нь түшиглэсэн үр дүнтэй хувилбарт үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлэв. Монгол Улсын Засгийн газарт 2009 онд таван "Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв" хүлээлгэж өгсөн юм.

Attention Given to Children in Need of Protection and Experiencing Hardships

From 2000, based on our experience, we began promoting the efficacy of a community-based approach and methodology for conducting child protection and development activities. We established community-based "Child Protection and Development Centers" and expanded social services for children lacking a safe living environment, parental love, and protection. For the first time in Mongolia, we introduced individual counselling, case management, family reunification, mentoring, and effective alternative family-based services. By 2009, five "Child Protection and Development Centres" had been established and officially handed over to the Government of Mongolia.



Хүүхэд төвтэй, хүүхэд удирдсан хөгжлийн үйл ажиллагаа

Олон улсын Нарны цирктэй хамтран “Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийг 2000 оноос Монгол Улсад эхлүүлэв. “Нийгэмшүүлэх цирк” нь хүнд нөхцөлд амьдарч буй хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, бие даасан байдлыг дэмжих, багаар ажиллах болон амьдрах ухаанд сургах зорилготой байв. Нийт 9.000 гаруй хүүхдийг уг хөтөлбөрт хамруулжээ. (Төслийн санхүүжүүлэгч Канадын Нарны цирк корпораци)

Child-Centered and Child-Led Development Activities

The “Social Circus” program was launched in Mongolia in 2000 in cooperation with the Canada’s Cirque De Soleil. This program aimed to enhance the physical strength and resilience of children and teenagers living in difficult conditions, foster self-sufficiency, and teach teamwork and life skills. Over 9,000 children participated in the program. (Funded by the Canada’s Cirque du Soleil)

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг дэмжив

Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэхэд анхаарч, 2003 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр батлахад дэмжлэг үзүүлэв. Үүний үр дүнд тусгай хэрэгцээтэй 8.000 гаруй хүүхэд ердийн сургалттай цэцэрлэг, сургуульд хамрагджээ. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан Олон нийтэд түшиглэсэн нөхөн сэргээх төвийг Улаанбаатар хот, Дорнод, Ховд, Баянхонгор, Баян-Өлгий аймагт 2000 оны эхээр байгуулав. Тус төслийн санхүүжүүлэгч нь Европын холбоо ТАСИС хөтөлбөр байв.



Supporting the Right to Education for Children with Special Needs

In 2003, Save the Children promoted the concept of inclusive education by supporting the adoption of a program aimed at the equal inclusion of children with disabilities in educational institutions. As a result, more than 8,000 children with special needs have been able to attend kindergartens and schools alongside their peers. Community-based rehabilitation centres for children with special needs were established in the early 2000s in Ulaanbaatar, Dornod, Khovd, Bayankhongor, and Bayan-Ulgii provinces. The above project was funded by European Union TACIS programmes.



Марк Лапорт

Марк Лапорт 1999-2003 онд Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь захирлаар ажиллаж байв. Тэрээр, олон нийтэд түшиглэсэн "Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв"-үүд байгуулахад анхаарахын зэрэгцээ боловсролын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, хөтөлбөрийг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, багш нарыг сургахад хүчин чармайлт гаргажээ.

Marc Laporte

Marc Laporte served as the director of Save the Children in Mongolia from 1999 to 2003. He focused on establishing community-based "Child Protection and Development Centres" and worked to enhance the infrastructure of the education sector. His efforts included improving training programs, increasing access to education, and providing training for teachers.

Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх анхны загвар

Хүүхдийг Ивээх Сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хамтран 2003 оноос орон нутагт хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үндсэн салбаруудыг татан оролцуулж, хамтарсан багаар ажиллах санаачилгыг амжилттай туршиж, үндэсний хэмжээнд бий болгов. Хүүхдийг Ивээх Сангаас хамтарсан багуудыг чадавхжуулах зорилгоор олон тооны ном, гарын авлага боловсруулан гаргасан бөгөөд өнөөг хүртэл хамтарсан багтай ажиллаж, чадавхжуулсаар байна. Тус төслийн санхүүжүүлэгч нь Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага - ЖАЙКА байв.

Developing an Early Model for Collaborative Child Protection Services

Since 2003, Save the Children and the National Center Against Violence have successfully tested a model of multidisciplinary teamwork and disseminated it nationally by involving key branches of child protection services at the local level. Save the Children has developed a series of effective practice books and manuals and continues to work with these multidisciplinary teams to strengthen their capacity and efficacy. The project was funded by the Japan International Cooperation Agency - JICA.



Үндэстний цөөнхийн хүүхдүүдийн боловсролыг дэмжив

Монголын нийт хүүхдийн таван хувийг эзэлдэг казах хүүхдүүдийн боловсролд анхаарлаа хандуулав. Баян-Өлгий аймагт 1998-2000 онд хэрэгжүүлсэн олон нийтэд түшиглэсэн төслүүд нь олон хүүхэдтэй, өрхийн орлого багатай өрхүүдийн орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих, тэдний хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Тус төслийг Английн Хүүхдийг Ивээх Сан санхүүжүүлсэн байна.

Supporting the Education of Ethnic Minority Children

We focused on the education of Kazakh children, who represent five percent of all children in Mongolia. The community-based projects implemented in Bayan-Ulgii province from 1998 to 2000 aimed to support initiatives that increased the incomes of families with multiple children and low household incomes, while also enhancing their children's access to schools and kindergarten. This project was funded by Save the Children UK.



Нэгдүгээр ангийн хүүхдүүдийг дэмжих загвар

Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх, сургуулийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарч, цогц үйл ажиллагаа хэрэгжүүлснээр 2003 оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулиуд арга зүй, туршлагатай боллоо. Үүний хүрээнд, багшийн арга зүйг сайжруулах, нэгдүгээр ангийнханд чиглэсэн сургуулийн бодлогыг боловсруулах, багш, сургууль, эцэг эх хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд "Харилцах дэвтэр" бий болгох зэрэг шинэлэг арга зүйг нэвтрүүлжээ. Олон нийтийн оролцоог хангах зорилгоор олон төрлийн сургалт, сурталчилгааны ажил хийсэн юм.

Model for Supporting First Graders

Since 2003, Save the Children has implemented comprehensive activities aimed at enhancing the learning abilities of first-grade students and strengthening school capacity for educating children at this critical stage. These efforts have enabled general education schools to adopt effective methodologies and gain valuable experience.

As part of these activities, we tested innovative approaches, including improving teaching methodologies, developing school policies specifically for first graders, and creating a "Communication Book" to facilitate effective communication and cooperation between teachers, schools, and parents. We also conducted a variety of training and promotional activities to ensure public participation.



2005-2014



Хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэхийг дэмжив

Монгол Улс дахь Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг төрийн бус байгууллагууд үнэлэх арга зүйн дэмжлэгийг 2004 оноос үзүүлж эхэлсэн. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд төрийн бус байгууллагуудаас 2004-2005, 2007-2009, 2013-2016 онд илгээсэн 3 удаагийн, хүүхдүүдийн 2 удаагийн бие даасан илтгэлийг тус тус дэмжин ажиллав. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо Монгол Улсын III, IV, V тайланг хүлээн авч, төрийн бус байгууллагууд болон хүүхдүүдээс хөндөж тавьсан хүүхдийн эрхийн асуудлуудыг хууль эрх зүй, бодлогын түвшинд анхаарч үзэх зөвлөмж, шаардлагыг Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн юм.

Encouraging Children to Express Their Opinions

Since 2004, we have provided methodological support to non-governmental organizations for evaluating the implementation of children's rights in Mongolia. We facilitated three independent reports submitted by these NGOs between 2004-2005, 2007-2009, and 2013-2016, as well as two independent reports submitted by children to the UN Committee on the Rights of the Child. The Committee accepted Mongolia's III, IV, and V reports and issued recommendations and requests for the Government of Mongolia to address the children's rights issues raised by NGOs and children at both the legal and policy levels.





Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Олон улсын өдөр

Хүүхдийг Ивээх Сангаас санаачлан 2006 оноос Монгол Улсад жил бүрийн 4 дүгээр сарын 30-нд "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдөр"-ийг уламжлал болгон тэмдэглэж ирэв. Манай улс нийгмийн бүх орчинд хүүхдийг зодож шийтгэхийг хуулиар хориглосон дэлхийн 49 дэх улс болох хүртэл энэхүү арга хэмжээ нь олон нийтэд нөлөөлсөн хүүхэд хамгааллын чухал санаачилга байлаа. Хүүхдийн эсрэг аливаа хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчих, хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг таслан зогсоохын чухлыг олон нийтэд сануулах энэ өдрийг өнөө хэр нь хамтрагчдынхаа хамтаар зохион байгуулж, Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг дэмжин ажиллаж байна.

International Day Against Corporal Punishment of Children

As a result of an initiative by Save the Children, Mongolia has observed the International Day Against Corporal Punishment of Children on April 30 every year since 2006. This event has served as an important child protection initiative, raising public awareness that led to our country becoming the 49th in the world to outlaw corporal punishment of children in all settings. Today, alongside our partners, we celebrate this day to remind the public of the importance of rejecting all forms of violence against children and to advocate for the cessation of physical and emotional punishment. The day of action also reflects our commitment to supporting the implementation of Mongolia's Law on Child Protection.



Хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, нийгмийн харилцааг дэмжив

Хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, нийгмийн харилцааг дэмжин хөгжүүлэх “Хүүхэд ба дуран” гэрэл зургийн хөтөлбөрийг Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран 2005-2009 онд хэрэгжүүлэв. Зорилтот сургуулийн хүүхдүүдэд чөлөөт цагаар нь мэргэжлийн багшаар гэрэл зургийн онол, дадлагын хичээл заалгаж, бүтээл хийх боломж бүрдүүлэв. Энэхүү төсөлд 70 гаруй хүүхэд хамрагдсан бөгөөд Монголын гэрэл зургийн салбарын залуу үеийн төлөөлөл болсон олон уран бүтээлч төрсөн юм. (Төслийн санхүүжүүлэгч Английн Арт Вентури, Монголын Урлагийн зөвлөл)

Supporting Children's Creativity and Social Relations

The “Focus on Kids” photography project implemented from 2005 to 2009 in cooperation with the Mongolian Arts Council, fostered children's creativity and social connections. Targeted schoolchildren learned how to take quality photographs through instruction in both the theory and practice of photography by a professional teacher during their free time. This opportunity allowed over 70 children participating in the project to create artwork through their photos. Many of them number amongst today's generation of emerging artists in the Mongolian photography industry. (Funded by the Art Venture UK, Mongolian Arts Council)



Карло Пушкарица

Карло Пушкарица 2003-2004 онд Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь захирлаар хоёр жил ажиллажээ. Тэрээр, Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөрөөс хүүхдийн эрхийн төлөө бусад оролцогч талуудыг уриалан нэгтгэхэд хувь нэмрээ оруулсан байна. Мөн хүүхдийн оролцоог хангахад анхаарч, тэднийг идэвхтэй хамтрагчид байх боломжийг бүрдүүлжээ.

Karlo Pushkaritsa

Karlo Pushkaritsa served as the director of Save the Children in Mongolia from 2003 to 2004. He played a key role in uniting various stakeholders around the cause of children's rights on behalf of Save the Children. Additionally, he advocated for children's participation, empowering them to become active partners in their own development.



Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх ажлыг санаачлав

“Монгол Улс дахь Хүүхэд хамгааллын тогтолцоо” бодлогын үнэлгээг 2006 онд хийж, хүүхдийг бүх төрлийн хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас хамгаалах тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байгааг нотлов. УИХ-ын Боловсрол, шинжлэх ухаан, нийгмийн бодлогын байнгын хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам энэхүү үнэлгээг сайшаан хүлээж авснаар Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцооны үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эхлэл болсон юм.

Initiating the Development of the National Child Protection System

In 2006, we conducted an assessment of the “Child Protection System in Mongolia” policy, highlighting the urgent need to strengthen the system to protect children from all forms of violence, harassment, exploitation, and neglect. The Standing Committee on Education, Science, and Social Policy of the Parliament, along with the Ministry of Labor and Social Protection, welcomed this assessment, marking the introduction of the concept of a comprehensive child protection system in Mongolia for the first time.



Хүүхэд бүрийн гэгээн мөрөөдөл болон эгшиглэв

Хүүхдийг Ивээх Сангийн хүсэлтээр Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Л.Балхжав, яруу найрагч Б.Лхагвасүрэн нар “Ертөнцийн хүүхдүүд” дуу зохиож, залуу уран бүтээлчид хамтран дуулж, олны хүртээл болгов. Хорвоо ертөнцийг хүүхдийн нүдээр харж, хонгорхон тэдний гэгээн мөрөөдлийг дуулсан энэхүү уран бүтээл нь хүүхдийн эрхэд анхаарлаа хандуулахыг насанд хүрэгчдэд уриалсан юм. Түүнчлэн Монголын хүүхдийн дууны урлагийн санд шинэ өнгө, шинэ аялгуу нэмсэн билээ.

Singing About Every Child's Dream

At the request of Save the Children, Honoured Cultural Worker of Mongolia, composer L. Balkhjav, and poet B. Lkhagvasuren created the song "Children of the World," which was performed by young artists for the public. This music, reflecting the world through the eyes of children and celebrating their sacred dreams, urged adults to take account of children's rights. Additionally, it enriched the Mongolian children's music industry with new trends and melodies.



Хүүхдийн эрхэд суурилсан боловсролын тогтолцоог бэхжүүлэхэд нөлөөлөв

Хүүхдийг Ивээх Сан иргэний нийгмийн бүлгүүдийг тэргүүлэн Боловсролын тухай хуульд багш нь суралцагчийн бие махбодод халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг задруулах, хууль бус төлбөр хураамж авахыг хориглосон нэмэлт өөрчлөлт оруулах нөлөөллийн ажлыг 2006 онд амжилттай хийж гүйцэтгэв. Энэ ажлын хүрээнд албан бус сургалт болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хувьсах зардлыг нэмэгдүүлж чадсан юм.



Influencing the Strengthening of the Education System Based on Children's Rights

In 2006, Save the Children spearheaded advocacy efforts with civil society groups to successfully amend the Law on Education. This amendment prohibits physical assault, emotional harassment, violation of privacy, and the charging of illegal fees by teachers. Through this initiative, we were also able to increase the variable budget for non-formal education and the education of children with disabilities.



Оролцооны загвар хөгжүүлэн хэрэгжүүлэв

Боловсролын орчинд сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор 2008-2011 онд сурагчдын зөвлөл, эцэг эх, багш нарын загвар холбоодыг байгуулах, чадавхжуулах төслийг Улаанбаатар хот болон Дорнод аймгийн төрийн өмчийн нийт 16 дунд сургуульд хэрэгжүүлэв. Архангай, Өвөрхангай, Сүхбаатар, Дорнод аймгийн 30 суманд 2013-2017 онд Олон нийтийн боловсролын зөвлөл байгуулж, боловсролын салбар дахь оролцооны хэлбэр болгоход арга зүй, техникийн туслалцаа үзүүлсэн байна. Тус төслийн санхүүжүүлэгч нь Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн сан байв.

Developing and Implementing the Participation Model

To strengthen good governance in the educational sector, we implemented a project to establish and build the capacity of student councils and model associations of parents and teachers in 16 public secondary schools in Ulaanbaatar and Dornod province from 2008 to 2011. Between 2013 and 2017, Community Education Councils were established in 30 soums across Arkhangai, Uvurkhangaï, Sukhbaatar, and Dornod provinces, and we provided methodological and technical assistance to create a robust participation model in the education sector. This project was funded by the Japan Social Development Fund, a World Bank Group Trust Fund.



Чулууны Тунгалаг

Чулууны Тунгалаг 2005-2007 онд Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь захирлаар хоёр жил ажиллажээ. Түүний хувьд хүүхдийн эрхэд суурилсан арга зүй боловсруулахад голлох үүрэгтэй оролцсон байна. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар үүрэг хүлээгчдээс хариуцлага шаардах, хүүхдэд ээлтэй засаглалыг хөгжүүлэх чиглэлд Хүүхдийг Ивээх Сан үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд анхаарлаа хандуулжээ.

Tungalag Chuluun

Tungalag Chuluun served as the director of Save the Children in Mongolia from 2005 to 2007. She played a significant role in developing a methodology centered on children's rights. Tungalag worked to expand Save the Children's efforts toward holding accountable those responsible for protecting children's rights and promoting child-friendly governance.



Хүмүүжлийн эерэг аргыг анх нэвтрүүлэв

Хүүхдийг Ивээх Сан хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, эрүүл хөгжлийг дэмжих үүднээс гэр бүл болон боловсролын орчинд хүмүүжлийн эерэг аргыг 2006 оноос идэвхтэй сурталчилж байна. Хүүхэд хамгаалал, боловсролын салбар дахь иргэний нийгмийн түншлэл, үйл ажиллагааны үр дүнд олон мянган эцэг эх, багш нар хүмүүжлийн эерэг аргад суралцан ашиглаж байна. Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан Хүмүүжлийн эерэг арга зүйн сургалтын модуль нь 2013 оноос салбарын ямаар магадлан итгэмжлэгдэж, мэргэжил дээшлүүлэх сургалтын салшгүй хэсэг болов.

Introducing Positive Parenting Methods for the First Time

Since 2006, Save the Children has actively promoted positive parenting methods within families and educational settings to protect children from violence and foster healthy development. Through partnerships with civil society and various activities in child protection and education, thousands of parents and teachers have learned and adopted these positive parenting techniques. In 2013, the Positive Education Method training module for preschool teachers was accredited by the Ministry of Education and Science, becoming an integral part of professional development training.





“Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн анхны загвар

2011-2014 онд “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийг хэрэгжүүлснээр нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүд хүүхдийн эрүүл ахуйд нийцсэн шинэ загварын ариун цэврийн өрөөтэй болсон юм. Түүнчлэн багш, эмчийн мэргэжил дээшлүүлэх гарын авлага бүхий магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр, үнэлгээний аргачлал бий болгосноор хүүхдэд илүү ээлтэйгээр гэр бүлийн оролцоог ханган ажиллах нөхцөл бүрдүүлсэн юм. Тухайн үед хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үзэл баримтлалыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх бодлого, эрх зүйн орчин бий боллоо.

The First Model of “Child-Friendly Kindergarten”

From 2011 to 2014, the “Child-Friendly Kindergarten” project introduced a new model of toilets in state kindergartens in Ulaanbaatar city that meets sanitation requirements for children’s hygiene. Additionally, we developed an accredited training program and assessment methodology, along with manuals for the professional development of teachers and health workers, fostering more child-friendly family participation. As a result, a policy and legal framework was established at the national level to promote the concept of child-friendly kindergartens.



Хүүхэд хамгааллаар төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэв

Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх төрөл бүрийн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг 2010 онд зохион байгуулав. Түүнчлэн Хүүхдийн төлөө үндэсний газрын бүх салбар, хэлтсийн ажилтнуудад хүүхэд хамгааллын бодлого боловсруулах арга зүйн дэмжлэг үзүүлж, хүүхдийн эрхэд суурилсан чиг хандлагын сургалтууд явуулав. Мөн Хүүхдийн төлөө үндэсний газрын хүсэлтээр 2010-2015 оны хүүхэд хамгааллын дунд хугацааны стратеги боловсруулахад нь дэмжлэг үзүүлсэн юм.

Strengthening the Capacity of Civil Servants in Child Protection

In 2010, in collaboration with the National Agency for Children, Save the Children organized training sessions, workshops, and discussions to enhance the child protection system. Additionally, we provided methodological support for the development of child protection policies to employees across all branches and departments of the National Agency for Children, and conducted orientation trainings centred on children’s rights. At the request of the National Agency for Children, we also contributed to the development of the 2010-2015 Mid-term Child Protection Strategy.

Засаглал дахь хүүхдийн оролцооны загварыг санаачлан эхлүүлэв

Хүүхдийг Ивээх Сан бодлого боловсруулах болон засаглалын түвшинд хүүхдийн оролцооны зарчмыг хэвшүүлэх зорилгоор "Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал" (2011-2013), "Хүүхдийн төлөө төсөв" (2013-2014), "Өсвөр үеийнхний эерэг хөгжил оролцоо" (2014-2015) төслүүдийг хэрэгжүүлэн, засаглалын бүх түвшинд "Хүүхдийн оролцоог дэмжих арга зүй ба журам"-ын төслийг боловсруулан Засгийн газарт өргөн барьсан. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлыг дэмжин хүүхдийн эрхийн сургалтуудыг зохион байгуулж байна.

Initiating a Model of Children's Participation in Governance

To promote the principle of children's participation in policy-making and governance, Save the Children implemented several projects, including "Children's Participation: Essential for Good Governance" (2011-2013), "Budget Analysis for Children" (2013-2014), and "Positive Participation by Youth" (2014-2015). We developed and submitted a draft of the "Methodology and Procedures for Supporting Children's Participation" to all levels of Government. Additionally, we organized training sessions on children's rights to empower children to express their opinions and support the implementation of recommendations from the United Nations Committee on the Rights of the Child.



Хуулийн хэрэгжилтийг дэмжин, хяналтын тогтолцоог сайжруулав

Улсын Их Хурлаар 2006 оны 12 дугаар сард Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, боловсролын салбарт бүх төрлийн хүчирхийлэл, дарамтыг хориглов. Сургуулиас хууль бус мөнгө хураахыг зогсоож, багш нарын мэргэжлийн ёс зүйн дүрэм бий болгон мөрдөх, хүүхдийн оролцоог дэмжих заалтуудыг хуульчлан баталсан юм. Хүүхдийг Ивээх Сан энэхүү хуулийн хэрэгжилтийг хянах практик бий болгох, боловсролын орчинд сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор Сурагчдын зөвлөл, эцэг эх, багш нарын загвар холбоо байгуулах, чадавхжуулах төслийг 2008-2011 онд хэрэгжүүлэв.

Supporting the Implementation of the Law and Improving the Monitoring System

In December 2006, Parliament amended the Law on Education to prohibit all forms of violence and harassment in the education sector. This amendment halted the illegal collection of fees from students, established a professional code of conduct for teachers, and included provisions to encourage children's participation. From 2008 to 2011, Save the Children implemented a project to establish and build the capacity of student councils and model parent-teacher associations. This initiative aimed to create sustainable practices for monitoring the implementation of the law and to strengthen good governance in the educational sector.



Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага дор үйл ажиллагаа явуулж эхлэлээ

Их Британийн Хүүхдийг Ивээх Сан дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралаас үүдэн 2009 онд олон улсад хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдээ эргэн нягталж, санхүүжилтээ багасгав. Ингэхдээ Монгол Улсад нээсэн салбараа хаах шийдвэр гаргасан байна. Гэхдээ Монгол Улсын хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын салбарт хүрсэн түвшин, бодлогын өөрчлөлт, олсон амжилтыг харгалзан Японы Хүүхдийг Ивээх Санд шилжүүлжээ. Ийнхүү Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр 2009 оны 8 дугаар сараас Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлага дор ажиллаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Transitioning to Management by Save the Children Japan

In 2009, in response to the global economic crisis, Save the Children UK re-evaluated its international programs and reduced funding, leading to the decision to close the branch in Mongolia. However, given Mongolia's progress in child rights and protection, as well as its policy changes and achievements, the Mongolia office was transferred to Save the Children Japan which has continued to guide the operation of Save the Children's programs and projects in Mongolia since August 2009.



2015-2024



Хүүхэд хамгааллын арга зүйн төв

Хүүхдийг Ивээх Сан 2015 онд “Хүүхэд төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, “Хүүхэд хамгааллын арга зүйн төв” болгон өөрчилж, стратеги төлөвлөгөөг нь шинэчилсэн юм. Ингэснээр “Хүүхэд хамгааллын арга зүйн төв” судалгаа, сургалт, мэдээлэл, зөвлөгөө, нөлөөлөл гэсэн таван чиглэлээр хүүхдийн эрхэд суурилсан хамгааллын тогтолцоог хөгжүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж эхлэв. Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд Монгол орны өнцөг булан бүрээс хандаж зөвлөгөө дэмжлэг авч, суралцдаг бүтэц болжээ.

Child Protection Resource Center

In 2015, Save the Children expanded the activities of the Child Centre, transforming it into the Child Protection Resource Centre and updating its strategic plan. As a result, the Centre began to focus on developing a child protection system prioritizing children’s rights in five key areas: research, training, information, advice, and advocacy. It has become a resource where child protection experts from across Mongolia seek and receive guidance and support.

Хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн анхны тусламжийн арга зүй

Аливаа гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын үндсэн үйлчилгээний нэг нь хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, нийгмийн харилцаанд оролцуулах явдал юм. Тиймээс 2016 оноос эхлэн зуд, үер зэрэг байгалийн гамшигт өртсөн хүүхдэд сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх сургалт явуулж, түншлэгч байгууллагуудын хамт үндэсний болон орон нутгийн түвшинд сургагч багш нар бэлтгэж, онцгой байдлын байгууллагын ажилтнуудыг чадавхжуулав.

Psychological First Aid for Children

Providing psychological support to children and facilitating their participation in social relationships is a fundamental child protection service during any disaster or emergency. Since 2016, we have conducted psychological first aid training for children affected by natural disasters, such as earthquakes and floods. We have also collaborated with our partner organizations to train trainers at both national and local levels and enhance the capacity of emergency response personnel.



Хамтдаа сурч, хөгжих тэгш боломж бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулав

Хүүхдийг Ивээх Сан нь хөгжлийн ялгаатай хүүхдүүд бусад хүүхдүүдтэй нэг ангид хамтдаа сурч хөгжих хууль эрх зүйн орчин бүрдүүлэхэд идэвхтэй оролцсоноос гадна сургуулиудын багш, ажилтны харилцаа, хандлагын арга зүйг сайжруулан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн мэдлэг ойлголт, үнэмшлийг өөрчилж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бүрдүүлж, Насан туршийн боловсролын төвийн чадавхыг сайжруулан сургуульд хамрагдахгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах боломж бүрдүүлэв. Тэгш хамруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүн, сайн туршлагад үндэслэн зөвлөмж боловсруулах замаар төрийн бодлого, зохицуулалтад нөлөөлөв. Боловсролд тэгш хамруулах төслүүдийг Япон Улсын Гадаад Хэргийн Яам санхүүжүүлсэн байна.

Contributed to Creating Equal Opportunities for Learning and Development

Save the Children is actively engaged in fostering a legal environment that allows children with developmental differences to learn and grow together in the same classroom. This involves improving the relationships and attitudes of school teachers and staff, as well as enhancing the knowledge and beliefs of parents, guardians, and the community. We helped to establish an inclusive education system in public schools, and strengthened the capacity of Lifelong Education Centres to reach children who are not attending school. Save the Children has influenced public policies and regulations by developing recommendations based on the results and best practices of projects focused on equal inclusion. Inclusive Education projects were funded by Ministry of Foreign Affairs of Japan.



Мицүаки Тоёода

Мицүаки Тоёода 2007 оноос Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн суурин төлөөлөгчөөр ажиллаж байгаад 2019 оноос Япон улсад үйл ажиллагааг үргэлжлүүлэн удирдах болжээ. Тэрээр 2009 онд Их Британийн Хүүхдийг Ивээх Сангаас Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлагад шилжих ажлыг удирдан зохион байгуулсан юм. Түүний хувьд Монголд 12 жил ажиллах хугацаандаа хүүхэд хамгаалал, боловсрол, хүүхдийн эрхийн засаглал, хүмүүнлэгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хүүхдүүдэд тулгарч буй буй чухал асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарч ажилласан байна. Мицүаки Тоёода хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгож, хүүхдийн бие махбодын шийтгэлийг бүхэлд нь хориглосон хуулийн шинэчлэлийг сурталчилан таниулахад гол үүрэг гүйцэтгэсэн аж.

Mitsuaki Toyoda

Mitsuaki Toyoda has served as the Country Director of Save the Children in Mongolia since 2007, continuing to oversee operations from Japan since 2019. He led the transition of the Mongolia Country Program from Save the Children UK to Save the Children Japan in 2009. During his 12 years in Mongolia, Mitsuaki strengthened child protection, education, child rights governance, and humanitarian programs to address critical issues affecting children. He played a key role in advocating for legal reforms that established a national child protection system and banned all corporal punishment of children.



Уралдаанч хүүхдүүдийн эрхийн төлөө хамтран ажиллалаа

Хурдан морины өвөл, хаврын уралдаанд хүүхдийг оролцуулан амь нас, эрүүл мэндэд нь эрсдэл учруулж, сурч боловсрох эрхийг нь зөрчиж байгаа нөхцөл байдлын эсрэг үндэсний төрийн бус байгууллагууд болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг санаачилсан. 2017-2018 онд хуулийн фирмтэй хамтран ажиллаж, өвөл, хаврын улиралд морь уралдуулах, хүүхдээр хурдан морь унуулахыг хориглох тогтоол гаргуулж үр дүнд хүрэв.

Collaboration for the Rights of Child Jockeys

We initiated cooperation between national non-governmental organizations and international bodies to address the risks to the lives and health of child jockeys participating in winter and spring horse races, while also advocating for their right to education. From 2017 to 2018, we partnered with a law firm to successfully secure a decree banning horse racing during winter and spring, as well as prohibiting children from participating in these races.



Орон нутгийн эрүүл мэндийн төвүүдийг дэмжив

Хөдөө орон нутгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор хоёр аймгийн гурван сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, эм тариа, лабораторийн урвалж бодис авахад дэмжлэг үзүүлэв. Эдгээр сумын эрүүл мэндийн төвд шинээр кабинет байгуулж, эмч, мэргэжилтнүүдийг сурган, шаардлагатай эм, хэрэгслээр хангаж байгаа юм. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор хүүхэд залуучууд, олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлуудыг үе шаттай зохион байгуулж байна. Хөдөө орон нутгийн эмнэлгүүдийг дэмжих төслийн санхүүжүүлэгч нь АНУ-ын Денан байгууллага байв.

Supporting Local Health Centers

To enhance medical care for rural populations, we supported three soum health centres in two provinces, helping them acquire essential equipment, medications, and laboratory reagents. These health centres established new treatment rooms, trained doctors and specialists, and are offering essential drugs and services. Additionally, we are organizing phased training and awareness activities focused on public health education for children, youth, and the community. Projects to support rural clinical have been supported by DENAN, an US-based donor.



Зураг дээр зүүн гар талаас: АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Монгол дахь Ахлах зөвлөх Томас Крехан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн Суурин Төлөөлөгч Л.Баян-Алтай

In the picture, from left to right, Thomas Crehan, Senior Development Advisor, USAID in Mongolia, S.Enkhbold, Minister of Health, L.Bayan-Altai, Country Manager of Save the Children in Mongolia



Дэлхийг цочроосон цар тахалтай тэмцэхэд оруулсан хувь нэмэр

Дэлхий нийтийг хамарч, сорилт бэрхшээл дагуулсан Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулах төсөл амжилттай хэрэгжүүлж, 21 аймаг, 330 сумыг хамруулав.

Төслийн хүрээнд нийт аймаг, сумын 660 гаруй эмч, эмнэлгийн ажилтныг “Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд Ковид-19 халдварын тохиолдлуудын эмнэлзүйн тусламж үйлчилгээг удирдахуй, хүчилтөрөгч эмчилгээ” сургалтад хамруулж, гарын авлага, эрчимт эмчилгээний 10 төрлийн протокол, 3 төрлийн постер, цахим сургалтын платформыг эмнэлзүйн тэргүүлэх мэргэжилтнүүдтэй хамтран орчуулан, хэвлүүлж эмч, мэргэжилтнүүдийн хүртээл болголоо.

Мөн Монгол Улсын 330 суманд хүчилтөрөгчийн 800 баллоныг дагалдах хэрэгслийн хамт хүлээлгэн өгөв. Түүнчлэн “Корона вирус цар тахлын үр нөлөөний түргэвчилсэн үнэлгээ” хийж, цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд тогтоосон хөл хорио хүүхэд, гэр бүлд хэрхэн нөлөөлж байгааг судалж мэдсэнээр хүн амд тулгарч буй нийгмийн хэрэгцээг тодорхойлсон байна. Ковид-19 цар тахлын үед гэрээс суралцаж байгаа хүүхдүүд болон тэдний эцэг эх асран хамгаалагчид, багш нарт зориулан сэтгэл зүйн зөвлөгөө, тусламжийг тасралтгүй хүргэж ажиллав. Энэхүү төслийн санхүүжүүлэгчээр АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, хамтран хэрэгжүүлэгчээр АНУ-ын FHI 360 байгууллага ажилласан болно.

Contributed to the global fight against the epidemic

We successfully implemented a project across 21 provinces and 330 soums to augment the response to the Covid-19 pandemic.

As part of the project, over 660 doctors and healthcare workers from all provinces and soums participated in training on “Clinical Care Management and Oxygen Therapy in Primary Health Care for Covid-19 Cases.” In collaboration with leading medical experts, we translated and published manuals, developed ten intensive care protocols, and created three types of posters and e-learning platforms, all made accessible to doctors and specialists.

Additionally, 800 oxygen tanks with accessories were distributed to 330 soums across Mongolia. We conducted an Rapid Assessment on the Effects of Covid Pandemic to identify the social needs faced by the population, examining the impact of the restrictions on children and families. Throughout the pandemic, we offered ongoing psychological counselling and support to children engaged in home schooling, as well as to their parents, guardians, and teachers. These important projects were funded by the USAID and were administered by FHI 360.

Хүүхэд, залуусын ардчиллын боловсролыг дээшлүүлэв

Хүүхэд, залуус өөрсдийн болон үе тэнгийнхэн, улс орныхоо өмнө тулгамдаж байгаа асуудал, сорилт, шийдлийн талаар ярилцаж, тодорхойлох, төр, нийгэмд дуу хоолойгоо хүргэх нь ардчиллын үнэт зэрчмын нэг юм. Хүүхэд, залуусын оролцоог хангах замаар ардчиллын үнэт зүйлсийг таниулж, сонгуулийн үйл явцад тэдний мэдлэгтэй оролцоог дэмжих зорилгоор төслүүд хэрэгжүүлэв. Тэдгээр төсөл хүүхэд, залуусын ардчиллын үйл явц, мэтгэлцээнд оролцох, хүний эрхийн мэдлэгт суурилсан оролцоог нь нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн иргэний боловсролын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх зорилготой байлаа. Ардчиллын боловсролын төслийг НҮБ-ын Ардчиллыг дэмжих сан санхүүжүүлсэн болно.

Enhancing Democratic Education for Children and Youth

Encouraging children and youth to discuss and define the challenges they face and to propose solutions is a fundamental principle of democracy. Save the Children implemented projects promoting democratic values among young people and facilitating their informed participation in the electoral process. These initiatives focused on strengthening their involvement in democratic discussions and processes, emphasizing knowledge of human rights, and supporting civic education programs in general education schools. These activities were supported by UN Democracy Fund.





Шинэ зуунд эрэлттэй хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол

21 дүгээр зууны иргэнд нэн хэрэгцээтэй хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл хэрэгжүүлж байна. Ингэснээр хүүхэд, залуус сурсан мэдлэг, ур чадвараа амьдралд хэрэглэх, асуудал шийдэх бүтээлч аргад хамтдаа суралцах боломж нэмэгдэж, сурлагын амжилт нь сайжран, ирээдүйн ажил, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэгдэж, сэтгэлгээ, ур чадвар нь хөгжиж байна. Хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох шинэлэг, оролцоонд тулгуурласан, төсөлд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, боловсролын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэв. Энэхүү хөтөлбөр Политехник коллеж, Мэргэжлийн боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн үндсэн судлагдахууны нэг болжээ. “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол” олгох төслийг Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн сан санхүүжүүлэв.

Fostering Personal Skills and Entrepreneurship Education for the 21st Century

We are implementing a project designed to cultivate personal skills and provide essential entrepreneurship education for the citizens of the 21st century. This initiative will empower children and young people to apply their knowledge and skills in real-life situations, encouraging creative problem-solving and improving academic performance. Participants will be better equipped for future employment, enhancing their critical thinking and practical skills.

We have developed an innovative, participatory, project-based curriculum for personal skills and entrepreneurship education, which has been implemented in collaboration with educational institutions.


This program has become a core subject in the curriculum of the Polytechnic College and of Technical and Vocational Training Institutions. The project to improve Entrepreneurship-Focused Socio-Emotional Skills For The Most Vulnerable Youth was funded by the Japan Social Development Fund, a World Bank Group Trust Fund.

Сэтгэцийн гэмтэлд суурилсан даван туулагчид ээлтэй үйлчилгээний арга зүйг таниулав

Хүүхдийг Ивээх Сан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгсдэд зориулан хүүхдийн сэтгэцийн гэмтэлд суурилсан даван туулагчид ээлтэй үйлчилгээний арга зүйг таниулав. Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа болон хамтран ажилладаг бүх талуудын мэргэжилтнүүдийн төлөөлөлд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах мэдлэг түгээв. Хүүхэдтэй харьцаж ажилладаг бүх хүн сэтгэцийн эрүүл мэнддээ анхаарал хандуулж, биеэ халамжлах нь тэднээс үйлчилгээ хүлээн авагч хүүхдэд цаг алдалгүй, чанартай үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэхэд чухал нөлөөтэйг мэргэжлийн түвшинд танилцуулав.

Introduced Trauma-Informed, Survivor-Friendly Service Methodology

Save the Children introduced a trauma-informed, survivor-friendly service methodology for child protection service providers. We shared insights on effectively addressing workplace burnout with experts and practitioners across the child protection field. At a professional level, we emphasized the importance of those working with children to prioritize own mental health and well-being in order to ensure effective delivery of timely and quality services.



ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН БОЛОН ВАЙРАЛ АГЕНТЛАГЫН ХАМТЫН БҮТЭЭЛ

Зөвлөл Д. Гэрэл-Од | Үйлчилгээ С. Батмөнх | Програмын О. Азбаяр | Бэлтгэгч Н. Гарамханд | Ерөнхий зорилго Р. Амарсанаа | Гэрээгээр П. Баярбат

Энэхүү БАРИМТАГ УРАН САЙХНЫ КИНО- "Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь" төслийн хүрээнд бүтээв.



Зураг дээр баруун гар талаас: БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн Удирдах зөвлөлийн дарга Уу Жүн

In the picture, from right to left: Oh Joon, Chairman of the Board of Save the Children Korea, is planting a tree during the opening of the My Forest Child Project, August 2024.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оролцож байна

Уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж байгаа төв цэгт Монгол орон оршиж байна. Манай Улс уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээнээс гаргасан судалгаагаар эмзэг, өртөмтгий 10 орны нэгт багтаж байна. Хүүхдийг Ивээх Сан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түлгарч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэх, нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулахад хүүхэд, эцэг эхчүүд, олон нийтийг татан оролцуулж, мэдлэг, ойлголтыг нь нэмэгдүүлэхээр "Ойн төгөл бүтээгч хүүхдүүд" төсөл хэрэгжүүлж байна. (Төслийн санхүүжүүлэгч БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сан)

Contributing to Mitigating Climate Change

Mongolia is at the forefront of climate change, ranking among the ten most vulnerable countries according to climate assessments. Save the Children is implementing the "My Forest Child" project to engage children, parents, and the community in efforts to mitigate climate change, address challenges, and reduce carbon emissions. The project has been funded by the Save the Children Korea.





Лувсандоржийн Баян-Алтай

Лувсандоржийн Баян-Алтай нь 2019 оноос Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчөөр ажиллаж байна. Түүний удирдлага дор Хүүхдийг Ивээх Сан хүүхэд хамгаалал, боловсрол, хүүхдийн эрхийн засаглал, эрүүл мэнд, хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр томоохон төслүүд хэрэгжүүлэв. Л.Баян-Алтай ажиллах хугацаандаа шинэ донор байгууллагуудыг оруулж ирэх талд дэвшил гаргасан юм. Хүүхдийг Ивээх Сан нь Дэлхийн Боловсролын Түншлэл (GPE), НҮБ-ын Ардчиллын сан, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын Итгэлцэлийн сан, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас санхүүжилт авчээ. Ялангуяа, дэлхийг хамарсан цар тахлын үед АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн эрүүл мэндийн төсөл нь олон мянган иргэний амь насыг авран хамгаалах боломж олгосон байна. Түүнчлэн Хүүхдийг Ивээх Сан болон Засгийн газрын яамд, агентлагууд, олон улсын болон орон нутгийн төр, захиргааны байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан юм.

Bayan-Altai Luvsandorj

Since 2019, L. Bayan-Altai has been serving as the Country Manager and Representative of Save the Children in Mongolia. Under his leadership, the organization has implemented major projects in child protection, education, child rights governance, health, and humanitarian assistance.

Bayan-Altai has successfully attracted new donor organizations, securing funding from the Global Partnership for Education (GPE), the United Nations Democracy Fund, the United Nations Trust Fund, and the Asian Development Bank. Notably, during the global pandemic, the health project funded by the United States Agency for International Development enabled Save the Children to save the lives of thousands of citizens. Additionally, he has fostered collaboration between Save the Children and government ministries, international organizations, and local government entities, strengthening partnerships for children's rights and well-being

Хүүхэд хамгааллын салбарын судалгааны чанарыг ахиулав

Хүүхдийг Ивээх Сан хүүхэд хамгааллын салбарт олон чухал судалгаа хийж, судалгааны арга зүйг хөгжүүлэв. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийг үнэлэх ТББ-уудын судалгаа тус бүрийг арга зүйгээр удирдан ажилласан юм. “Өсвөр үеийнхний дуу хоолой” сэдэвт үе шаттай судалгаанууд явуулж, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх нөлөөллийн ажлуудын гарааны болон барианы үнэлгээгээр хэмжих туршлагыг танилцуулав. Хүүхэд хамгааллын талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадлын судалгаа хийж, Хүүхэд хамгааллын мэдээллийн системийн 4 програмыг үнэлсэн нь тус улсад анхдагч байлаа.

Improving the Quality of Research in the Field of Child Protection

Save the Children has conducted significant studies and developed a robust research methodology in the child protection sector. We provided appropriate methodologies to NGOs assessing the implementation of the UN Convention on the Rights of the Child. Our phased “Young Voices” surveys revealed insights into the impact of advocacy activities on children's rights and protection through initial and final evaluations.

Notably, we conducted the first assessment in Mongolia of adults' knowledge, attitudes, and practices regarding child protection, as well as the first evaluation of four programs within the child protection information system.





Сургуультай хамтран хүүхэд хамгааллын чадавхийг бэхжүүлж байна

Сургуульд суурилсан хүүхэд хамгааллын арга зүйг хөгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах зохицуулалт, хяналтын тогтолцооны загвар бий болгохоор ажиллаж байна. Сургуулийн орчинд сурагчдад эрхийг нь мэдүүлж, эрхийн зөрчлийг таньдаг болгож, хэрэв зөрчил гарсан бол хэнд, хаана, хэрхэн хандахыг зааж зөвлөв. Аливаа эрсдэл тулгарсан үед өөрийгөө халамжлах болон үе тэнгийнхэндээ сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үр чадварт сургах, хүүхэд хамгааллын асуудлаар хүүхдийн дүү хоолойг холбогдох байгууллагуудад хүргэж, бодлого журмуудад тусгах ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа юм. (Төслийн санхүүжүүлэгч Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл)

Strengthening Child Protection Capacity in Collaboration with Schools

We are developing a school-based child protection methodology and creating a model regulatory and monitoring system of prevention, early detection and response to violence against children. In the school environment, we inform students of their rights, raise awareness about potential violations, and guide them on who to contact and how to seek help if a violation occurs. Additionally, we teach children both self-care skills and how to provide psychological support to their peers in times of risk, ensuring their voices are heard by relevant institutions and integrated into policies and procedures. The project to establish School-Based Child Protection Mechanism in Mongolia was funded by Save the Children Hong Kong.





Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн аюулт үзэгдэл, хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг, ослын давтамж ойртон, тоо нь ихсэж байна. Эдгээр хүчин зүйл нь хүүхдэд учрах аливаа эрсдэл, эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байгаа юм. Хүүхдийг Ивээх Сан гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудалд Засгийн газар, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ холбогдох мэргэжилтнүүдийн чадварыг бэхжүүлэх, хүүхэд, эцэг эхчүүд, олон нийтийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, эрсдэлийг бууруулах талаар мэдлэг, ойлголт, хандлагад нөлөөлөх олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлж ирлээ.

Child Protection During Disasters and Emergencies

The frequency of natural hazards driven by global warming, as well as disasters and accidents caused by human factors, is on the rise, increasing the risk and vulnerability of children. Save the Children collaborates with government and professional organizations on child protection and disaster risk reduction during emergencies. We strengthen multi-faceted partnerships to build the capacity of relevant experts and to enhance the knowledge, understanding, and attitudes of children, parents, and the public regarding risk prevention and protection.



Хэрэгцээтэй үедээ эзэндээ хүрсэн хүмүүнлэгийн тусламжууд

Байгалийн гэнэтийн аюул, давагдашгүй хүчин зүйл болон үер, ган, зуд, шуурганд өртөж хохирсон айл, өрх, хүүхдүүдэд хүмүүнлэгийн тусламжуудаа хүргэсээр ирлээ.

Хэрэгжүүлсэн гол төслүүд:

- Баянхонгор, Ховд аймгийн зудад өртсөн малчдад туслах (2001 он)
- Дорнод аймагт гарсан гар хөл, амны өвчний хорио цээрийн үеийн тусламж (2001 он)
- Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай сумын зудад нэрвэгдсэн иргэдэд туслах (2003 он)
- Зудад өртсөн малчин өрхийг дэмжих (2016)
- Зудад өртсөн малчин өрхийн амьжиргааг хамгаалах, малчдын хүүхдүүдийн сэтгэлзүй, эрүүл мэндийн болон боловсролын хэрэгцээг хангах (2016-2017 он)
- Үерт өртсөн орон нутгийн гэр бүл, хүүхдэд боловсрол, нийгэмсэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь (2018-2019 он)
- Зудын хүндрэлээс урьдчилан сэргийлэх нь (2018-2019 он)
- Шороон шуурганд өртсөн хүүхэд, малчин өрхийн амьжиргааг дэмжих (2021 он)
- Зудад өртсөн малчид, малчдын хүүхдүүдэд туслах (2023 он)
- Үерийн гамшигт өртсөн Баянзүрх дүүргийн гэр бүл, хүүхдүүдэд туслах (2023 он)
- Зудад өртсөн малчин өрхүүдэд туслах (2024 он)
- Малжуулах (2024 он)

Монголд хүмүүнлэгийн төрөл бүрийн төслүүд хэрэгжүүлэхэд биднийг дэмжсэн ажилласан Олон улсын Хүүхдийг Ивээх Сангийн “SEED” Хүмүүнлэгийн Сан, Японы Хүүхдийг Ивээх Сан, БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сан, Их Британийн “СТАРТ” сан, Швейцарын хөгжлийн агентлаг, Япон Платформ Сан зэрэг бүх хандивлагчдадаа баярлалаа.

Humanitarian Aid Reaching Those in Need

We continue to provide humanitarian aid to families and children affected by sudden natural hazards, including floods, droughts, dzud, and sandstorms. Our key projects include:

- Supporting herders impacted by dzud in Bayankhongor and Khovd provinces (2001)
- Providing assistance during the quarantine for hand, foot, and mouth disease in Dornod province (2001)
- Providing aid to communities affected by dzud in Aadaatsag and Erdenedalai soums of Dundgobi province (2003)
- Humanitarian support to herder families during dzud disaster (2016)
- Protecting the livelihoods of herder households suffering from dzud conditions and addressing the psychological, mental, and educational needs of their children (2016-2017)
- Delivering educational and socio-psychological support to families and children affected by floods (2018-2019)
- Dzud anticipation project (2018-2019)
- Supporting livelihoods of children and herders impacted by sandstorms (2021)
- Assisting herders and their children affected by dzud (2023)
- Aiding families and children in the flood-affected Bayanzurkh district (2023)
- Providing assistance to herder households impacted by dzud (2024)
- Livestock restocking project (2024)

We thank many donors who have supported us in implementing various humanitarian projects in Mongolia. They include SC Seeds Fund, SC Korea, SC Japan, SC Switzerland, Japan Platform and Global Start Fund of the UK.



Манай үйл ажиллагаа Монгол орныг бүхэлд нь хамарлаа

Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагаа газар зүйн байршлын хувьд Монгол орны баруун Алтайгаас Дорнын уудам тал, Монгол Шарын даваанаас Орвог гашууны бор толгой хүртэл эх орны дөрвөн зүг, найман зовхист өргөжин тэлэв. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Дорнод, Архангай, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Говьсүмбэр, Сэлэнгэ зэрэг 9 аймагт салбар нэгжээ байгуулж, нийслэл Улаанбаатар хот болон түүний 9 дүүрэг, 21 аймаг, 330 суманд төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа хүрсэн байна.

Our Activities Cover the Whole of Mongolia

Save the Children's efforts span the entirety of Mongolia, reaching from the Mongolian "Sharyn Davaa" pass in the north to the brown hills of Orvog Mountain in the south. Over the past 30 years, we have established branches in nine provinces: Dornod, Arkhangai, Khovd, Gobi-Altai, Bayankhongor, Uvurkhangai, Sukhbaatar, Gobisumber, and Selenge. Our projects and programs have been implemented in the capital city of Ulaanbaatar, its nine districts, as well as across 21 provinces and 330 soums.



Хүүхэд бүрийн амар амгалан, итгэлтэй ирээдүйн төлөө

Хүүхдийг Ивээх Сан үйл ажиллагаагаа алхам алхмаар өргөжүүлж, хүүхэд хамгаалал, хүүхдийн боловсрол, хүүхдийн эрхийн засаглал, эрүүл мэнд, хүүхдийн ядуурлыг бууруулах зэрэг тэргүүлэх чиглэлүүдэд хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсээр байна. Шинэ зууны хүүхэд багачуудад нэн шаардлагатай үр чадвар, боловсрол, сэтгэлгээ хөгжүүлэх чиглэлд анхаарал хандуулж байна. Хүүхэд бүр аливаа хүчирхийллээс хамгаалагдаж, бие сэтгэцийн хувьд эрүүл байж, боловсролтой, зорилго, хүсэл мөрөөдөлтэй, аз жаргалаар дүүрэн хөгжих, оролцох боломж, нөхцөлийг бүтээхийн төлөө үүрэг хүлээгч бүх тал хүчин чармайлт гаргахыг Хүүхдийг Ивээх Сан уриалж байна.

Монголын хүүхэд бүрийн гэрэлт ирээдүйн төлөөх бидний амжилт, ололтын түүх цаашид ч тасралтгүй хөгжсөөр, үргэлжилсээр байх болно.

For the Peaceful and Secure Future of Every Child

Save the Children is progressively expanding its initiatives, implementing programs in key areas such as child protection, education, rights governance, health, and poverty reduction. We emphasize the development of essential skills and critical thinking for the children of the new century.

We urge all stakeholders to collaborate in ensuring that every child is protected from violence, enjoys physical and mental well-being, receives an education, nurtures their goals and dreams, experiences happiness, and has the opportunity to participate fully in society.

Together, we will continue to build on our successes and achievements for the bright future of every Mongolian child.











Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн бүх ажилтнууд, 2023 оны 12-р сарын 22
All staff of Save the Children in Mongolia, 22 December 2023

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН

1994-2024

Зөвлөх: Л.Баян-Алтай, Ё.Нямдаваа, Х.Дэлгэрзаяа, Б.Булган,
Э.Оюунмаа, Ч.Мөнгөнтүяа, Ч.Пүрэв-Очир

Редактор: Э.Цолмон, М.Хулан, Ч.Батпүрэв

Гэрэл зураг: Хүүхдийг Ивээх Сангийн архив

Дизайн: Л.Лхагвачимэг

Зохиогчийн эрх © Хүүхдийг Ивээх Сан/Save the Children / 2024 Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төвийн 4 давхар
Утас: 11329365, 11329371

SAVE THE CHILDREN IN MONGOLIA

1994-2024

Advisors: L.Bayan-Altai, Yo.Nyamdavaa, Kh.Delgerzaya, B.Bulgan,
E.Oyunmaa, Ch.Munguntuya, Ch.Purev-Ochir

Editors: E.Tsolmon, M.Khulan, Ch.Batpurev

Photo: Save the Children Archives

Layout and design: L.Lkhagvachimeg

Copyright © Save the Children / 2024 Save the Children

Address: 4th floor of Arizona Center, 1st khoroo, Chingeltei district, Ulaanbaatar city
Phone: 11329365, 11329371

